

БАТЛАВ
ЗАСАГ ДАРГА *Д.Мөнхбаатар* Д.МОНХБААТАР

**ТӨВ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН МЭС ЗАСЛЫН
ВАКУУМ ӨРӨӨНИЙ ЗУРАГ, ТӨСӨВТ ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

МЭС ЗАСЛЫН ВАКУУМ ӨРӨӨ БОЛОН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

- ✓ Мэс заслын вакуум хагалгааны өрөө – 2
- ✓ Мэс заслын дараах сэрээх өрөө -1
- ✓ Ариун цэврийн өрөө (эр, эм тусдаа душтэй байх)
- ✓ Хувцас солих өрөө (эр, эм)
- ✓ Анхдагч багаж, хэрэгсэл угаах өрөө
- ✓ Цэврийн бүс рүү нэвтрэх хэсэг
- ✓ Гар угаах хэсэг
- ✓ Эм тариа бэлтгэх өрөө
- ✓ Бохир хадгалах өрөө
- ✓ Тоног төхөөрөмжийн техникийн өрөө

**ВАКУУМ МЭС ЗАСЛЫН ӨРӨӨНД ТАВИГДАХ ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
ШААРДЛАГЫГ ХАНГАСАН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МАТЕРИАЛ ТООЦООЛЛООР
АЖЛЫН ЗУРАГ, ТӨСВИЙГ БОЛОВСРУУЛСАН БАЙНА.**

- Шинээр хийх хагалгааны өрөөний хийн системийг эмнэлгийн хийн системтэй холбох
- Агааржуулалтын тоног төхөөрөмжийн өрөөг байрлуулах тохиромжтой байршлыг сонгож, мэс заслын өрөөтэй холбох шийдлийг гаргах
- Мэс заслын өрөө болон цэврийн коридорын хаалгыг автомат хаалгаар, техникийн өрөө болон бусад өрөөнүүдийн хаалгыг мэс заслын өрөөний зориулалтын ган хаалгаар хийсэн байх
- Гар угаалгын хэсэг нь хөл мэдрэгчтэй зориулалтын ган байх
- Ажлын даалгаварт тусгагдсан өрөөнүүдийн цонх, хаалга, сантехник, агааржуулалтын шинэчлэлтийг бүрэн хийх
- Нийт ажлын талбайн хэмжээ: вакуум мэс заслын өрөөний 25 м² бүхий 2 өрөө. Бусад талбай-267м²

АЖЛЫН ДААЛГАВАР

Г үйцэтгэх ажил	Тавигдах шаардлага
Агаар боловсруулах тоног төхөөрөмж угсралт /АНК/	<p>Агаар цэвэршүүлэх, агаар халаах, агаар хөргөх, агаар чийгшүүлэх, агаар ариутгах үйлдлийг нэг дор хийх боломжтой; автомат компьютер хяналтын системтэй, агаарын автомат тохируулгын хаалтуудтай, өгөх буцах агаарын шугам хоолойтой холбогдсон байх.</p> <ul style="list-style-type: none">- Агаар цэвэршүүлэх хүчин чадал: тооцооллоор,- Хөдөлгүүрийн хүчин чадал: тооцооллоор;- Хөргөлтийн хүчин чадал: тооцооллоор,

	<ul style="list-style-type: none"> - Шинэ агаар халаах хүчин чадал: тооцооллоор, - Үндсэн цахилгаанаар халаах хүчин чадал: тооцооллоор, - Агаар чийгшүүлэх хүчин чадал: тооцооллоор, - Чийгшүүлэгчийн халаагуурын хүчин чадал: тооцооллоор, - Цахилгаан эрчим хүч: 380 вольт, - Зэс хоолойгоор гаднах хөргөлтийн тоног төхөөрөмжтэй холбогдсон байх,
PLC компьютер систем угсралт	Орчин үеийн хяналтын программ сууринуулах боломжгой өндөр хүчин чадалтай.
Мэс заслын өрөөнд Нера филтер сууринуулах	H-14 доошгүй хүчин чадал бүхий 99,99 хувь доошгүй агаарыг шүүх хүчин чадалтай
Зориулалтын металл хавтангаар мэс заслын өрөөний хана хийх /Clean room panel/	1.2мм доошгүй зузаантай металл гадаргуутай зориулалтын тоосжилт үүсдэгтүй, бактер хуримтлагдах, үржих боломжгүй гадаргуутай, арчиж цэвэрлэхэд хялбар, гипсэн хавтан хүчитгэлтэй Clean room panel хавтангаар хана хийх.
Зориулалтын металл хавтангаар мэс заслын өрөөний тааз хийх / Clean room panel /	1.2мм доошгүй зузаантай металл гадаргуутай зориулалтын тоосжилт үүсдэггүй, бактер хуримтлагдах, үржих боломжгүй гадаргуутай, арчиж цэаэрлэхэд хялбар, гипсэн хавтан хүчитгэлтэй Clean room panel хавтангаар тааз хийх.
Мэс заслын хэсгийн бусад хана, таазыг хийх	4мм доошгүй зузаантай металл гадаргуутай зориулалтын тоосжилт үүсдэггүй, бактер хуримтлагдаж, үржих боломжгүй, гадаргуутай, арчиж цэвэрлэхэд хялбар Clean room panel хавтангаар хана тааз хийнэ.
Тэгш өнцөгт огтлолтой агаар дамжуулах, агаар өгөх буцах шугам хоолой угсралт	Тооцооллоор өнцөгг огголтой салхивчийн хоолой хийж гүйцэтгэнэ. Галд тэсвэртэй, эрүүл ахуй аюулгүй ажиллагааны шаардлага хангасан 20мм зузаан Rubber материалыар дулаалсан 30x30мм булан төмрөөр фланец угсарч өгөх буцах шугам хоолойнууд хийсэн байх. Агаарын шугам хоолойнд дуу намсагч, агаарын хаалтуудыг тооцооллоор угсралт
Удирдлагын самбар угсралт (Агаар боловсруулах төхөөрөмжийн тохиргоны самбар)	Мэс заслын эхлэх дуусах цаг, орон нутгийн цаг гардаг, өрөөний температур, чийгшил, хийн заалтыг харах боломжгой байх.

Мэс заслын өрөөнд мэдээгүйжүүлгийн багаж хэрэгсэл, эм тариа хадгалах шүүгээ угсрах	Мэс заслын өрөөний зориулалтын, зэвэрдэггүй 1мм зузаантай ган материалыаар хийсэн, нүдэнд харагдахгүй аргаар гагнасан, арчиж цэвэрлэхэд хялбар, 4-өөс доошгүй тавиуртай, цоожтой шургуулгатай байх. Хананд ухаж суулгасан байх.
Мэс заслын багаж хэрэгсэл хадгалах шүүгээ	Мэс заслын өрөөний зориулалтын, зэвэрдэггүй 1мм зузаантай ган материалыаар хийсэн, нүдэнд харагдахгүй аргаар гагнасан, арчиж цэвэрлэхэд хялбар, 4-өөс доошгүй шилэн тавиуртай байх. Хананд ухаж суулгасан байх.
Эм тариа, ороох боох материал хадгалах шүүгээ угсрах	Мэс заслын өрөөний зориулалтын, зэвэрдэггүй 1мм зузаантай ган материалыаар хийсэн, нүдэнд харагдахгүй аргаар гагнасан, арчиж цэвэрлэхэд хялбар, 4-өөс доошгүй шилэн тавиуртай байх. Хананд ухаж суулгасан байх.
Мэс заслын өрөөнд тэмдэглэл хөтлөх эвхэгддэг тавцан суурилуулах	Мэс заслын өрөөний зориулалтын, зэвэрдэггүй 1мм зузаантай ган материалыаар хийсэн, нүдэнд харагдахгүй аргаар гагнасан, арчиж цэвэрлэхэд хялбар, 4-өөс доошгүй шилэн тавиуртай байх. Хананд ухаж суулгасан байх.
Рентген хальс харах гэрлийн самбар суурилуулах	Мэс залын өрөөний зориулалтын, 4-өөс доошгүй стандарт хальс нэгэн зэрэг байршуулж харах боломжтой. Хананд ухаж суулгасан байх
Мэс залын автомат гар угаагуур суурилуулах	З-аас доошгүй хүн нэгэн зэрэг угаах боломжтой, автомат хүний гарын оролцоогүй ус нээгдэж хаагддаг зэвэрдэггүй ган материалыаар хийгдсэн, арчиж угаахад халбар гар угаагуур суурилуулах, Тольтой гэрэлтэй байх.
Мэс заслын өрөөнд автомат хаалга угсрах	Хөл мэдлэгчтэй 1,2 мм-ээс багагүй зузаан гангаар хийсэн автомат хаалгатай байх, мэс заслын өрөөний зориулалттай. Шилэн цонхтой байх.
Цэврийн бүсэд автомат хаалга угсрах	Хөл мэдлэгчтэй 1,2 мм-ээс багагүй зузаан гангаар хийсэн автомат хаалгатай байх, мэс заслын өрөөний зориулалттай. Шилэн цонхтой байх.
Цэвэр орчинд зориулагдсан ган хаалга	Бактерийн эсрэг хамгаалалттай 1,2 мм зузаан гангаар хийсэн нэг хавтастай ган хаалга байх
Мэс заслын өрөөнд шаардлагатай газруудад 220, 380 вольтын газардуулгатай цахилгаан разетка угсрах	Мэс заслын өрөөний зориулалтын, зэвэрдэггүй 1 мм зузаантай ган материалыаар хийсэн, нүдэнд харагдахгүй аргаар гагнасан, арчиж, цэвэрлэхэд хялбар. Хананд ухаж суулгасан байх, нэг мэс заслын өрөөнд 6-аас доошгүй ишигүүр залгаж хүрэлцэхүйц байх, олон тусмаа сайн байх.

Гэрэлтүүлэг LED	Мэс залын өрөө болон туслах өрөөнүүдэд тусгай clean room зориулалтын туслах LED гэрлүүд суурилуулах
Тусгай эмнэлгийн зориулалтын хулдаасан шалхийх /Gerflor/	2мм-ээс багагүй зузаантай вакуум хагалгааны өрөөний зориулалттай, цул бүтэцтэй, цахилгаанждаггүй байх ба залгааг гагнаж наана.
Мэс заслын өрөөний хананд эмнэлгийн хийн хангамжийн холболтын консоль системийн самбар угсралт	4 төрлийн хийн DIN стандартын хошуу орох холболттой монометр хэмжигчтэй байх. Мэс заслын өрөөний зориулалтын зэвэрдэггүй 1 мм зузаантай ган материалаар хийсэн, нүдэнд харагдахгүй аргаар гаргасан, арчиж цэвэрлэхэд хялбар. Хананд ухаж суулгасан байх. Хүчилтөрөгч, агаар, нүүрстөрөгч, азот, вакуум зэрэг 5 төрлийн герман стандартын DIN хошуугаар холбогдох боломжтой. Тус төхөөрөмжийг эмнэлгийн хийн системтэй зэс хоолойгоор гагнаж холбох.
Сэрээх өрөөний орны толгойн консоль систем	2-оос доошгүй төрлийн хийн DIN стандартын хошуу орох холболттой, 220 вольтын разетка суурилуулсан байх, сувилагч дуудах калл систем байрлуулах.
Агаар чийгшүүлэгч төхөөрөмж	Чийгшүүлэх хүчин чадал 15кг/цаг доошгүй, Халаагуурын хүчин чадал 11.3 kW багагүй.
Температур ба чийгшил мэдрэгч	Агаарын даралт, температур, чийгшлийн тоон мэдээлэл дамжуулах
Өрөөний температурын автомат тохиргоо	Өрөөний температурыг хөргөх, дулаацуулах автомат горим бүхий тохируулгатай байх
Таазанд суурилагдсан дүүжин тоног төхөөрөмж Ceiling pendant	Хийн холболтын тоо хангалттай байх, Даалт даах чадвар өндөртэй, илүүдэл агаар гаргагчтай байх, интернет, телефон холболттой байх, цахилгаан разетканы тоо хангалттай байх, тавиур, шүүгээтэй байр, Эргэх өнцөг 270°
Шинэ агаар оруулах сэнс	Агаар сорох хүчин чадал, хөдөлгүүрийн хүчин чадал, хөдөлгүүрийн эргэлт агаарын даралт тооцооллоор
Өрөөний агаар гаргах сэнс	Агаар гаргах хүчин чадал, хөдөлгүүрийн хүчин чадал, хөдөлгүүрийн эргэлт агаарын даралт тооцооллоор
Дусал хийх тарианы суурь	0.8м-аас 1.35 метр хүртэл сунгах өвчтөн, эмч, сувилагч нарын хэрэгцээнд хүртээмжтэй байх. Салган авах болон шилжүүлэхэд хялбар байх.
Дижитал дэлгэц	Тоног төхөөрөмжийн цахилгаан хэлбэлзлийг харуулах дижитал дэлгэцтэй байх

Ажлын талбайтай танилцаж, нарийвчилсан хэмжилтийг хийх шаардлагатай бөгөөд нэмэлт мэдээллийг тодруулгаар авна.


Ажлын даалгаврыг боловсруулахдаа дараах ижил төстэй ажлуудын даалгавраас тусгасан болно.

<https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1589517196394>

<https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1547441407032>


<https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1633943780665>

Хянасан: АНЭ-ийн дарга



Н.Энхтайван

Боловсруулсан: АНЭ-ийн ЭТТ-ийн инженер



Б.Өлзийбүрэн